

МОНГОЛБАНК (ТӨВ БАНК) нь
Зөвлөх үйлчилгээ үзүүлэх сонирхолтой этгээдийг саналаа ирүүлэхийг урьж байна.
“Арилжааны банкуудын санхүүгийн байдлын үнэлгээ”
Төслийн дугаар: Cons 01/2017

Монголбанк нь арилжааны банкуудын санхүүгийн байдлын үнэлгээг гүйцэтгэх зөвлөх сонгох тул сонирхсон хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. **Энэхүү зөвлөх үйлчилгээ** нь банкуудыг актив хөрөнгөө зохистой үнэлж, чанаргүй активын алдагдлаас хамгаалах хангалттай өөрийн хөрөнгөтэй эсэхийг тогтоосноор Монголын банкны салбарын тогтвортой байдалд үнэлэлт дүгнэлт өгч, банкуудын эрсдэлийн удирдлагын аргачлалыг сайжруулах зөвлөмжийг боловсруулах зорилготой. Зөвлөхөөр хөндлөнгийн үнэлгээг хийлгэснээр үнэлгээнд хамрагдаж буй банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварын үзүүлэлт нь ирээдүйд активын чанар буурч, эрсдэлийн санг нэмэгдэхэд зохистой түвшинд байгаа эсэхийг Монголбанкнаас баталгаажуулах боломж бүрдэх юм.

Зөвлөх нь Монголбанктэй гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлийн 90 хоногт багтаан Үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Зөвлөхөд олон улсад нэр хүнд бүхий зөвлөх үйлчилгээний компани байх, Активын чанарын иж бүрэн үнэлгээ (AQR)-г Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын гишүүн орнуудад түгээмэл ашигладаг аргачлалын дагуу гүйцэтгэж байсан болон зээлийн эрсдэлийн удирдлагын аргачлалын үнэлгээг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хийж байсан чадвар, туршлагатай байх үндсэн шаардлагыг тавина. Уг гэрээт ажлыг гүйцэтгэх **санхүүгийн ба техникийн** чадвартай, сонгон шалгаруулалтын (**дэлгэрэнгүй жагсаалтын**) шаардлагыг хангасан болохоо нотолсон зөвлөхийг дараагийн шатны шалгаруулалтад оролцуулна.

Оролцогчийн шалгуур болон бусад шаардлагатай мэдээллийг Монголбанкны <https://www.mongolbank.mn/documents/notice.pdf> хаягаар орж үзнэ үү.

Зөвхөн хураангуй жагсаалтад орсон этгээдтэй холбоо барина.

Монголбанк нь гэрээт ажлыг гүйцэтгэх санхүүгийн ба техникийн чадваргүй талаар дүгнэсэн зөвлөхийг сонгон шалгаруулалтад оролцуулахгүй байх эрхтэй.

Энэхүү зөвлөх үйлчилгээний талаар нэмэлт мэдээлийг 2017 оны 04 дүгээр сарын 03-наас 19-ний өдрүүдэд 11:00-17:00 (Улаанбаатарын цагаар) цагийн хооронд etender@mongolbank.mn цахим шуудан болон 976-11-328482; 976-11-320847 дугаарын утсаар холбогдож авна уу.

Хугацаа: Сонирхсон зөвлөх саналаа шаардлагатай баримт, материалын хамт доорх хаягаар **2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн** (Улаанбаатарын цагаар) **15:00** цагаас өмнө ирүүлнэ үү.

Н.Батсайхан, Үнэлгээний хороо
Монголбанк, Бага тойруу 3, Улаанбаатар 46, 15160, Улаанбаатар, Монгол улс.
Төв хаалга, Өрөө-2 (бичиг хэрэг)
утас: 976-11-328482 факс: 976-11-311471